

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ,  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

(2023 оны байдлаар)

2023.12.13

№	Шийдвэрийн дэс дугаар, огноо	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр	Биелэлт	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7
<b>Монгол улсын хууль</b>						
1			<i>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль</i>	<p>Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр 895, үүнээс мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын дагуу хүүхдийн нөхцлөөр 179, 4.7 дугаар заалтын дагуу малчин нөхцлөөр 328, тахир дутуугийн тэтгэвэр 315, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 88, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 3, цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр 8, нийт 1413 иргэний тэтгэврийг шинээр, НДСОТТТХуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу 463 тэтгэвэр авагчдын тэтгэврийг өөрчлөн тус тус тогтоож хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.</p> <p>2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн Засгийн Газрын 238 дугаар тогтоол “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, өөрчлөлт оруулах тухай”, мөн Засгийн газрын “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолоор 2023 оны 07 дугаар сарын 01-нээс тэтгэврийн нэмэгдлийг хийж гүйцэтгэсэн.</p>	100%	
2		6.3 Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто	<i>Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29</i>	Хэлтсийн эзэмшлийн Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг иргэд, даатгуулагчдад хүрч үйлчлэх зорилтыг хангах чиг үүргийн дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурлыг аймгийн төвөөс алслагдсан 6 сумдад зохион байгуулахдаа ашиглаж байна. Аймагт төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллага байгуулагдаагүй болно.	100%	

		тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.				
		11.1 Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй		2023 онд 4 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах бөгөөд 125,6 сая төгрөгийн тэтгэмжийн зардал төсөвлөгдсөн ба 2023 оны хагас жилд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу албан хаагч тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 2 албан хаагчийн 40,4 сая төгрөгийг олгосон бөгөөд давхардуулан олголт хийгдээгүй.	100%	
3		8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 С	Байгууллагын эрхэм зорилгын хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээг хурдан шуурхай, мэргэжлийн түвшинд үзүүлж, иргэд даатгуулагчдынхаа сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллаж байна. 2023 онд батлагдсан төсөв 154408888.6 мянган төгрөг бөгөөд үүнээс зарцуулсан нь: -Тэтгэврийн даатгалын сангаас 22162 тэтгэвэр авагчдад 147898104.6 мянган төгрөгийн тэтгэвэр -Тэтгэмжийн даатгалын сангаас 3752 даатгуулагчдад 4487505.5 мянган төгрөгийн тэтгэмж -ҮОМШӨ сангаас 63 тэтгэвэр авагчдад 508895.8 мянган төгрөгийн тэтгэвэр, 14 даатгуулагчид 13244.2 мянган төгрөг тэтгэмж, төлбөр -Ажилгүйдлийн даатгалын сангаас 449 даатгуулагчид 956466.3 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын хуулийн дагуу цаг хугацаанд нь бүрэн олгосон.	100%	
		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;		Нийгмийн даатгалын багц хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт, цахим үйлчилгээ, үндсэн үйл ажиллагаа, бүтэц орон тооны зураглал, цаг үеийн мэдээ, мэдээллийг <a href="https://huvsgul.ndaatgal.mn/about-us/">https://huvsgul.ndaatgal.mn/about-us/</a> веб сайтад тухай бүрт нь шинэчилж, Хөвсгөл аймгийн НДХ page хуудсанд 24 удаа мэдээ байршуулснаар 297 like, 27 comment, 356 share, НДЕГазраас хийсэн мэдээлэл, постерийг давхардсан тоогоор 62 байцаагч share хийж 32031 иргэний хандалт хийж үзсэн байна. Хэлтсийн <a href="https://huvsgul.ndaatgal.mn/about-us/">https://huvsgul.ndaatgal.mn/about-us/</a> хуудсанд 70382700, 70382572 дугаарыг байршуулж, тус дугаарт 86 дуудлага хүлээн авч шийдвэрлэсэн байна.	100%	
		8.2.3. эдийн засаг,		2023 онд:	100%	

		<p>нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>		<p>-Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой гарч болзошгүй эрсдэлтэй байдлыг тодорхойлж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулсан хэлтсийн удирдлагыг мэдээллээр хангаж, энэ ажлын хүрээнд хэлтэс сумдын байцаагч нарт чиглэл, арга зүйн сургалт зөвлөмжийг цахимаар 3, танхимын сургалтаар 2 удаа хийсэн.</p> <p>- Аймгийн 23 сумын 2019-2021 онд шинээр тогтоогдсон 5312 тэтгэврийн мэдээллийг нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сантай тулган шалгах ажлыг зохион байгуулсан. Үүнээс: Өндөр нас-4453, Тахир дутуу-567, Тэжээгчээ алдсан-292</p> <p>-2023 онд Арбулаг, Жаргалант, Бүрэнтогтох, Баянзүрх, Ренчинлхүмбэ, Эрдэнэбулган, Улаан-Уул, Тосонцэнгэл, Алагэрдэнэ, Их-Уул, Хатгал, Цагааннуур, Галт Цагаан-Үүр, Цагаан-Уул сумдын 2022 онд шинээр тогтоогдсон 890 тэтгэврийн тогтоолт, олголтыг хувийн хэрэг дэх үндсэн баримттай тулган шалгаж 5 тэтгэвэр авагчтай холбоотой 61076,4 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож 12566,3 мянган төгрөгийг барагдуулсан. 2022 онд зогсоогдсон 1021 тэтгэврийн хувийн хэргийг шалгаж хэлтсийн архивт шилжүүлсэн. Үүнээс: ӨН-483, ТА-101, ТД-437 ТХХ хамрагдсан байна.</p> <p>-Тэтгэвэр тогтоолт, олголттой холбоотой эрсдлээс урьдчилан сэргийлж хэлтэс, сумдын байцаагч болон хяналтын байцаагч нарт 2 удаа зөвлөмж өгсөн. Хяналт шалгалтын танилцуулга-3</p> <p>-Тэтгэвэр тогтоолт, баримт бүрдүүлэлтэй холбоотой Их-Уул, Баянзүрх болон хэлтсийн тэтгэвэр олголтын байцаагчид 4 улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Хяналт шалгалтын тайлан танилцуулга</p> <p>-Хэлтсийн хэмжээнд гарч болзошгүй эрсдэлт нөхцлүүдийг урьдчилан тодорхойлж хэлтсийн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах чиглэлд анхаарч ажилласан.</p> <p>-Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 149 төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагаас 89 төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын 2021-2022 оны санхүүгийн анхан шатны баримт, тайланд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.</p> <p>-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 48 ажил олгогч байгууллага дээр 6864,1 мянган төгрөгийн акт, 2059,0 мянган төгрөгийн алданги тавьсан. Актын барагдуулалт 100 хувь байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/50</p>		
--	--	--	--	--	--	--

			<p>дахь “Заавар батлах тухай” тушаалаар батлагдсан “Цахим хяналт шалгалтын ажлын заавар”-ыг хэрэгжүүлж, 2023 оны эхний хагас жилд /давхардсан тоогоор/ давхар тэтгэвэр авдаг 3215, нас барснаас хойш файл бэлдсэн 22 /давхардсан тоогоор/ тэтгэвэр авагчийн мэдээллийг хянав. Цахим хяналтаар 6 тэтгэвэр авагчтай холбоотой 5500,0, мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож 900,0 мянган төгрөгийг барагдуулж, актын биелэлт 83,6 хувьтай байна.</p> <p>- Хяналт, шалтгалт дотоод аудитын тасгаас хэлтэс сумдын нийт 46 байцаагч ажилтнуудад арга зүйн зөвлөмжийг цахимаар 3, шалгалтын танилцуулгаар 3, мөн хэлтсээс зохион байгуулсан сургалтаар 2 удаа тус тус өгсөн байна. Энэ нь байцаагч ажилтнууд зөвлөмжийн хүрээнд эрсдлээс урьдчилан сэргийлэх, бүртгэл мэдээллийг сайжруулах, баримт шинжлэх, ажлын арга зүйд суралцахад чиглэгдсэн болно.</p> <p>-Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 23 сумын тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн хувийн хэргийн бүрдлийг хянан шалгалаа. Тэтгэврийн хувийн хэргийн бүрдэл болох ХЧАлдалтын хувь, хугацаа сунгуулсан актын бүрдэл, баталгаажилтыг тулган шалгаж хүн нэг бүрээр тэмдэглэл хөтөлсөн. Үүнд: Мөрөн сумын 910, 22 сумын 1842 иргэн нийт 2752 иргэний актын бүрдлийг хянан шалгасан байна.</p> <p>Мөн ХЧАлдалтын хувь, хугацааг сунгуулдаг Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 48 иргэний тэтгэврийн хувийн хэргийг хянан шалгаж хугацаагүйгээр тогтоолгосон 2 иргэний ХЧАлдалтыг дахин магадлаж хэвээр сунгасан болно.</p>		
		<p>8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;</p>	<p>Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй хүрээнд: Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан тухай бүрт 216, сар бүр оруулах -96, хагас жилээр -8, бүтэн жилээр мэдээллэх-22, нийт 342</p>	<p>100%</p>	

			<p>мэдээлэлд, хяналт тавьж ажилласан.</p> <p>-2023 онд Хөвсгөл аймгийн Прокурорын газраас Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зохион байгуулсан сургалтанд хамрагдсан. Сар бүрийн 15-ны дотор прокурорын газарт өргөдөл гомдлоо хянуулж хэвшсэн. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 6 байгууллагыг 3000,0 мянган төгрөгөөр торгох хариуцлага тооцож, шийтгэврийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд торгуулийг 100 хувь, барагдуулсан байна. Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий байцаагч нар аймгийн Прокурорын газарт зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь тайлагнасан.</p>		
		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	<p>Шинэ сэргэлтийн бодлого батлагдсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж байгууллагаас хамаарах заалтад санал өгч Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулж ажилласан болно.</p>	100%	
		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<p>Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай, НДСОҮОМШӨТТТТухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн болон холбогдох бусад хууль шийдвэрүүдийн талаар 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөх зөвлөмж, Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх хянах журам, чиглэл, арга хэмжээний талаар ХНХЯ болон НДЕГазраас ирсэн нийт 37 албан бичгийг хэлтсийн албан хаагчдад 7 хоног бүрийн Даваа гаригийн өглөөний сонсголоор, хэлтэс, сумдын байцаагч нарт албан хаягаар хүргүүлж хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүргийг тасгийн дарга нарт өгч ажиллалаа. Мөн сумдад ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар 10 удаагийн сургалтыг цахимаар, танхимаар 2 удаа хийж нэгдсэн ойлголтыг өгч ажилласан болно. 2023 онд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <p>1/ Ажил олгогч нийгмийн даатгалын таван төрөлд үйл ажиллагааны чиглэлээс хамааран нийтдээ хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоосоо 12.5, 13.5, 14.5</p>		

				<p>хувь, албан журмын даатгуулагч хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо 11.5 хувь, сайн дурын даатгуулагч 13.5 хувиар, хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байгаа жирэмсний, амаржсаны тэтгэмж авсан сайн дураар даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төгрөг)-ний 12.5 хувьд ногдох хэсгийн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг өөрөө хариуцан төлсөн тохиолдолд үлдсэн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг тэтгэмжийн даатгалын сангаас, харин бусад сайн дураар даатгуулагч эх 50.0 хувь (34375 төгрөг)-ийг өөрөө хариуцан төлсөн тохиолдолд үлдсэн 50.0 хувь (34 375 төгрөг)-ийг улсын төсвөөс тус тус тооцон шимтгэл төлнө.</p> <p>2/ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард таван зуун тавин мянган (550 000) төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.</p> <p>3/ Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (550 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалд 1.0 хувь, нийтдээ 12.5 хувиар буюу 68 750 төгрөгөөр тооцно.</p> <p>4/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/191дүгээр тушаалаар даатгуулагчийн төрлийн “70”, “71” шинэ кодыг баталсан зэрэг өөрчлөлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>4/Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн “Итгэлцүүр шинэчлэн батлах тухай” 238 дугаар тогтоол, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолуудын дагуу аймгийн хэмжээнд 21715 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж олгосон.</p> <p>5/Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай” А/136 дугаар тушаалыг байцаагч ажилтнуудад танилцуулж мөрдлөг болгон ажиллаж байна.</p>		
--	--	--	--	---	--	--